



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2024 оны 08 сарын 09 өдөр

Дугаар 4143

Улаанбаатар хот

Зардал гаргах тухай

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны "Нийслэлийн 2024 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай" 25 дугаар тогтоол, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Засаг даргын 2023 оны "Эрх шилжүүлэх тухай" А/1391, А/1392, А/1393 дугаар захирамжаар батлагдсан төсөл арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх явцад шаардагдах үлдэгдэл санхүүжилтийг Нийслэлийн 2024 оны төсөвт тусгасан "Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд дэд бүтэц, инженерийн байгууламжийн засвар үйлчилгээний зардал"-аас санхүүжүүлэхээр тооцож, жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

2.Хавсралтаар батлагдсан төсөл арга хэмжээнүүдийн ажлын явцад хяналт тавьж, ашиглагч байгууллагуудын өмчид бүртгэлжүүлэх ажлыг чиг үүргээр хангаж ажиллахыг Хотын инженерийн дэд бүтцийн газар (М.Балдандорж)-т даалгасугай.

3.Энэхүү тушаалын хавсралтаар батлагдсан 565,041,225 (Таван зуун жаран таван сая дөчин нэгэн мянга хоёр зуун хорин тав) төгрөгийг "Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд дэд бүтэц, инженерийн байгууламжийн засвар үйлчилгээний зардал"-аас гүйцэтгэлээр санхүүжүүлэхийг Захиргаа, санхүүгийн удирдлагын газрын Ахлах нягтлан бодогч (Б.Халиун)-д зөвшөөрсүгэй.

4.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн удирдлагын газар (Н.Отгонбаяр)-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Ц.ТӨРХҮҮ

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
 2024 оны 08 дугаар сарын 28 өдрийн
 тушаалын хавсралт

ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
 ХҮРЭЭНД УЛААНБААТАР ХОТ НИЙТИЙН АЖ АХУЙН
 ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ЖАГСААЛТ

	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсөвт өртөг	Тухайн онд санхүүжих дүн
1	2	3	4
1	Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ – Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хорих 421 дүгээр ангийн гадна татуургын шугам ажил	85,940,156	85,940,156
2	Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ – 170 дугаар цэцэрлэгийн барилга, цахилгааны засварын ажил (СХД, 25 дугаар хороо) 200.000.000	42,761,591	42,761,591
3	Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ – Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн гэрэлтүүлгийн дэд станцын өргөтгөл, кабелийн шугамын засварын ажил БГД, БЗД, СХД, ЧД	34,000,000	34,000,000
4	Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ – БЗД, 120 дугаар сургуулийн халаалтын зуухны хүчин чадлыг нэмэгдүүлэх хийн халаагуур нийлүүлж суурилуулах ажил	27,928,668	27,928,668
5	Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ – Багахангай дүүргийн 1 дугаар хороо халаалт, хэрэгцээний халуун усны шугамын засвар шинэчлэлт	103,992,958	103,992,958
6	Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ – УДД-132 төв 10-58 дугаар байрны гаргалгаанаас 1-58 дугаар байрны оруулга хүйтэн усны 5 хос шугам шинэчлэн солих	25,799,944	25,799,944
7	Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ – Жаргалант тосгоны эрүүл мэндийн төвийн Амбулаторийн барилгын дээвэр сантехникийн засвар (СХД)	7,272,754	7,272,754
8	Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ – Боловсрол цогцолбор сургууль дотор халаалтын систем цэвэр усны шугамны засвар (Багануур дүүрэг 3 дугаар хороо)	110,205,411	110,205,411

1	2	3	4
9	Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ – 79 дүгээр цэцэрлэгийн сантехникийн засварын ажил (СХД, 18 дугаар хороо)	17,094,512	17,094,512
10	Хэрмээдэй ХХК – Халаалтын уурын зуухны барилгын өргөтгөл, барилга угсралтын ажил	73,040,046	73,040,046
11	Геодези, усны барилга, байгууламжийн газар ОНӨААТҮГ – Борооны ус зайлуулах шугам сүлжээний ажил (СХД 18 дугаар хороо)	37,005,194	37,005,194
	НИЙТ ДҮН	565,041,225	565,041,225